



## **НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛЭГ ХӨТЛӨХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмаар аудит хийж буй төрийн аудитын байгууллагын албан хаагч болон төрийн аудитын байгууллагын нэрийн өмнөөс төрийн аудитын үйл ажиллагаанд оролцож буй этгээд /цаашид "Албан хаагч" гэх/ -ээс нөлөөллийн мэдүүлэг хөтлөхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2.“Нөлөөллийн мэдүүлэг” гэж Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-т зааснаар аудит хийх явцад тухайн аудитын үр дүнтэй холбогдуулан төрийн аудитын байгууллагад аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан баримт бичгийг ойлгоно.

### **Хоёр. Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, хүргүүлэх**

2.1.Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэхээр төлөвлөсөн санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн, нийцлийн аудит бүрд “Нөлөөллийн мэдүүлэг”-ийн талаар шалгагдагч талд тайлбарлан энэхүү журмын 2 дугаар хавсралт /Нөлөөллийн мэдүүлгийн талаар танилцуулсан баримт/-д гарын үсэг зуруулж, танилцуулна.

2.2.Албан хаагч нь шууд болон шууд бусаар аудитын үйл ажиллагаанд нөлөөлөхийг оролдсон дараах үйлдлийг энэхүү журмын 1 дүгээр хавсралт /Нөлөөллийн мэдүүлэг/ маягтын дагуу хөтөлж, баримтжуулна. Үүнд:

- 2.2.1.Хээл хахууль, шан харамж, бэлэг сэлт өгөх, өгөхийг завдах
- 2.2.2. Албан тушаал санал болгох, /өөрт болон хамаарал бүхий этгээдэд/
- 2.2.3.Дарамт шахалт үзүүлэх /дээд албан тушаалын эрх бүхий этгээдээс/
- 2.2.4.Дарамтлах, заналхийлэх, сүрдүүлэх
- 2.2.5.Гүтгэх, доромжлох
- 2.2.6.Бие, орон байр, унааны аюулгүй байдалд халдах
- 2.2.7.Аудитын дүгнэлт, тайланг урьдчилан хэлэлцэхийг санал болгох
- 2.2.8.Аудитын дүгнэлт, тайлангийн талаар урьдчилан зааварчилгаа өгөх
- 2.2.9.Бусад



2.3.Албан хаагч нь аудитын явцад энэ журмын 2.2 дахь хэсэгт заасан нөлөөлөл гарсан талаар мэдэгдэж, нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй нь түүнд хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

2.4.Албан хаагч нь нөлөөллийн мэдүүлгийг хөтөлсөн тухай бүрд зөвхөн Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлэх бөгөөд “Монгол Улсын Ерөнхий аудиторын гарт” гэж хаяглан, дугтуйлж битүүмжилсэн байна.

### **Гурав. Нөлөөллийн мэдүүлэг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, шилжүүлэх**

3.1.Нөлөөллийн мэдүүлгийг Монгол Улсын Ерөнхий аудитор хүлээн авч танилцаж, холбогдох ажиллагаа хийлгэхээр Үндэсний аудитын газрын хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгж, ажилтанд тухайн өдөрт нь шилжүүлнэ.

3.2.Хууль эрх зүйн асуудал хариуцсан нэгж, ажилтан нь нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн албан хаагчаас болон нөлөөлөх оролдлогыг гэрчлэх этгээдээс тайлбар, тодруулга авах, холбогдох нотлох баримтыг бүрдүүлэх зэрэг ажиллагааг ажлын 5 өдрийн дотор хийж, Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулна.

3.3.Нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн албан хаагч болон нөлөөлөх оролдлогыг гэрчлэх этгээдтэй биечлэн уулзах боломжгүй тохиолдолд холбооны хэрэгсэл, цахим технологийг ашиглана.

3.4.Монгол Улсын Ерөнхий аудитор нөлөөллийн мэдүүлэг болон түүнд холбогдох баримттай танилцаж, шаардлагатай гэж үзвэл Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

3.5.Нөлөөлөх оролдлого хийсэн тухайн этгээдийн үйлдлийг Төрийн аудитын байгууллагын бие даасан, хараат бус байдалд халдсан, аудит хийхэд хөндлөнгөөс нөлөөлсөн гэж үзвэл түүнийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандан шийдвэрлүүлэхээр Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр гаргана.

3.6.Дээрх гарсан шийдвэрийг ажлын нэг өдөрт багтаан холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

3.7.Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариу ирүүлээгүй тохиолдолд хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан эрх бүхий этгээдээс шалгалтын явцын талаар мэдээлэл авах, тухайн нөлөөллийн мэдүүлгийг нэн даруй шалгаж, хариу ирүүлэх талаар хүсэлт гаргах зэргээр холбогдох арга хэмжээг авна.

### **Дөрөв. Нөлөөллийн мэдүүлгийн талаар мэдээлэх**

4.1.Энэ журмын 3.4, 3.5-д заасны дагуу гарсан шийдвэрийн талаарх мэдээллийг Үндэсний аудитын газрын цахим хуудаст ажлын нэг өдөрт багтаан байршуулна.

4.2.Энэ журмын 3.6-д заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн хариуг ажлын нэг өдөрт багтаан Үндэсний аудитын газрын цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.



### **Тав. Нөлөөллийн мэдүүлгийг хадгалах**

5.1.Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгж, ажилтан нь нөлөөллийн мэдүүлэг болон түүнд холбогдох бусад баримтыг зохих журмын дагуу хадгалж, архивд хүлээлгэн өгнө.

5.2.Нөлөөллийн мэдүүлэг, түүнд холбогдох баримт материал, тэдгээрт дурдсан мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

### **Зургаа. Хариуцлага**

6.1.Энэ журмыг зөрчсөн албан хаагчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

--- хХх ---



## НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛЭГ

Нэг. Ерөнхий зүйл	
1.1.	Мэдүүлэг хөтлөгчийн овог, нэр
1.2.	Байгууллага, албан тушаал
1.3.	Гүйцэтгэж буй аудитын мэдээлэл

Хоёр. Нөлөөллийн арга, хэрэгсэл	
2.1.	Шууд /хэн, хэзээ, хаана уулзахыг ямар арга, хэрэгслийг ашиглан санал болгосон/ ..... ..... ..... .....
2.2.	Шууд бус /дамжуулсан этгээдийн тухай, харилцаа холбооны болон хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ашиглан нөлөөлсөн ..... ..... ..... .....

Гурав. Нөлөөллийн хэлбэр	
3.1.	Хээл хахууль, шан харамж, бэлэг сэлт өгөх, өгөхийг завдах
3.2.	Албан тушаал санал болгох, /өөрт болон хамаарал бүхий этгээдэд/
3.3.	Дарамт шахалт үзүүлэх /дээд албан тушаалын эрх бүхий этгээдээс/
3.4.	Дарамтлах, заналхийлэх, сүрдүүлэх
3.5.	Гүтгэх, доромжлох
3.6.	Бие, орон байр, унааны аюулгүй байдалд халдах
3.7.	Аудитын дүгнэлт, тайланг урьдчилан хэлэлцэхийг санал болгох
3.8.	Аудитын дүгнэлт, тайлангийн талаар урьдчилан зааварчилгаа өгөх
3.9.	Бусад

#

Дөрөв. Тусгай мэдээлэл
------------------------



4.1.	Нөлөөлөх оролдлого давтагдсан байдал	
4.2.	Гэрчлэх этгээдийн тухай мэдээлэл	
4.3.	Нөлөөлөх оролдлогыг баримтжуулсан материал байгаа эсэх	

#

Тав. Хавсаргасан материал		
5.1.	Нөлөөлөх оролдлогыг баримтжуулсан материал /гэрчлэх этгээдээс авсан тайлбар, тодруулга, албан бичиг, захидал, дуу, дүрсний бичлэг гэх мэт/	

Мэдүүлэг хөтөлсөн ..... / /

..... он ..... сар ..... өдөр



## НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛГИЙН ТАЛААР ТАНИЛЦУУЛСАН БАРИМТ

.....  
/Аудитын нэр, код/

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-т “Нөлөөллийн мэдүүлэг” гэж аудит хийх явцад тухайн аудитын үр дүнтэй холбогдуулан төрийн аудитын байгууллагад аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан баримт бичгийг” ойлгоно гэж заасан.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын байгууллагын албан хаагчид аливаа этгээдээс нөлөөлсөн бүх үйлдэлд Төрийн аудитын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт заасны дагуу “Нөлөөллийн мэдүүлэг” хөтөлнө.

Нөлөөллийн мэдүүлэгт дурдсан мэдээллийг шалгуулах, хуульд заасан хариуцлага ногдуулах асуудлыг Монгол Улсын Ерөнхий аудитор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандан шийдвэрлүүлж, энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тухай бүрд нь нийтэд мэдээлнэ.

Нэг. Шалгагдагч байгууллагыг төлөөлж:

№	Албан тушаал	Овог, нэр	Гарын үсэг	Огноо
1				
2				
3				

Хоёр. Төрийн аудитын байгууллагыг төлөөлж:

№	Албан тушаал	Овог, нэр	Гарын үсэг	Огноо
1				
2				
3				